



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/135

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.17, Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан "Аймаг бүрт 1000 айл"-ыг орон сууцжуулах бодлогын хүрээнд 120 айлын "Түрээсийн орон сууц" ашиглалтанд орж, иргэдэд түлхүүр гардуулах үйл ажиллагаа зохион байгуулсантай холбогдуулан хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 426600/ дөрвөн зуун хорин зургаан мянга зургаан зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 611

03 Аймгийн Засаг даргын 2017 оны  
..... дугаар сарын..... өдрийн .....  
дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт хоногийн тоо	Мөнгөн дүн /төгрөг/
1.	Буудал	3 ортой 2 өрөө	50000	3	300000
2.	Оройн хоол	6 хүн	21100	1 удаа	126600
3.	Нийт				426.600